



МОНГОЛ УЛС  
ТӨВ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН  
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 4/02

Зуунмод

Түрээсийн орон сууц хүлээн авах,  
хүлээлгэн өгөх ажлын хэсэг  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улс, орон нутгийн хөрөнгөөр болон түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журмын 2.1.2, 2.1.3, 2.1.4, 3.6-д заасны дагуу түрээсийн орон сууцыг орон нутгийн өмчлөлд шилжүүлэн авах, бүртгэх, түрээслэгчдэд хүлээлгэн өгөх, авах байнгын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Баярсайхан (Орон нутгийн өмчийн газрын Өмчийн бодлого, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн)

Гишүүд:

Б.Мөнхбаяр (Орон нутгийн өмчийн газрын Өмчийн ашиглалт, хяналт худалдах, актлах, шилжүүлэх харилцааг зохицуулах мэргэжилтэн)

Г.Уранцэцэг (Орон нутгийн өмчийн газрын Өмчийн бүртгэлийн хяналт хариуцсан мэргэжилтэн)

2. Тушаалын 1 дэх заалтад тусгагдснаар түрээсийн орон сууцыг хүлээн авах, бүртгэх, түрээслэхдээ холбогдох хууль, тогтоомж, дүрэм журмыг чанд мөрдөн, мэдээ тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, танилцуулан ажиллахыг ажлын хэсэг (Б.Баярсайхан)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАТЖАРГАЛ